



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/34/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaa.T@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 70332860 Цахим хаяг: Nerguibaatar.d@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ж.Мөнгөншагай Утас: 90909190 Цахим хаяг: Mungunshagai.J@audit.gov.mn</p>
------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Агуулга

1.Аудитын дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг

Утас/Факс: 976-70333141

И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2022.02.22 № 38.
танай _____-ны № _____-т

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Г.ГАЛСАНДОРЖ
ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	23,411,908.63	48,835,983.63
МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	10,000.00
Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	10,000.00
Төгрөг	0.00	10,000.00
Арилжааны банк дахь харилцах	0.00	10,000.00
БАРАА МАТЕРИАЛ	23,411,908.63	48,825,983.63
Түүхий эд материал	8,395,131.00	11,827,899.50
Тусгай зориулалттай материал	8,395,131.00	11,827,899.50
Бэлэн бүтээгдэхүүн	3,554,730.00	3,569,730.00
Хангамжийн материал	11,462,047.63	33,428,354.13
Бичиг хэргийн материал	1,212,483.00	1,205,583.00
Аж ахуйн материал	0.00	7,990,000.00
Бусад хангамжийн материал	10,249,564.63	24,232,771.13
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	46,309,576.41	200,329,530.36
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	46,309,576.41	200,329,530.36
Газар	0.00	0.00
Биет хөрөнгө	46,309,576.41	200,329,530.36
Машин тоног төхөөрөмж(компьютер)	183,766,022.98	256,599,852.98
Хуримтлагдсан элэгдэл	-151,832,983.01	-68,531,074.33
Тавилга, аж ахуйн эд хогшил	41,118,770.00	42,192,670.00
Хуримтлагдсан элэгдэл	-26,742,233.56	-29,931,918.29
Програм хангамж	5,690,450.00	5,690,450.00
Хуримтлагдсан элэгдэл	-5,690,450.00	-5,690,450.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	69,721,485.04	249,165,513.99
НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	10,000.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	10,000.00
Урьдчилж орсон орлого	0.00	10,000.00
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	0.00	10,000.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	69,721,485.04	249,155,513.99
Засгийн газрын хувь оролцоо	69,721,485.04	249,155,513.99
Хуримтлагдсан үр дүн	69,721,485.04	249,155,513.99
Өмнөх үеийн үр дүн	45,048,296.86	69,721,485.04
Тайлант үеийн үр дүн	24,673,188.18	179,434,028.95
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	69,721,485.04	249,165,513.99

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	744,297,856.40	855,191,350.28
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	46,917,956.40	230,195,250.28
3	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,255,000.00	170,802,830.00
4	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	24,255,000.00	170,802,830.00
5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,365,705.00	635,675.28
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	21,297,251.40	58,756,745.00
7	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	697,379,900.00	624,996,100.00
8	Улсын төвлөрсөн төсвөөс	531,435,000.00	532,211,800.00

9	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	531,435,000.00	532,211,800.00
10	Нэмэлт санхүүжилтийн орлого	165,944,900.00	92,784,300.00
11	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	165,944,900.00	92,784,300.00
12	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	719,624,668.22	675,099,731.43
13	УРСГАЛ ЗАРДАЛ	719,624,668.22	675,099,731.43
14	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	713,461,515.71	674,446,270.43
15	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	416,376,887.88	415,025,700.00
16	Үндсэн цалин	338,072,045.08	354,759,058.77
17	Нэмэгдэл	72,144,842.80	51,026,697.08
18	Унаа хоолны хөнгөлөлт	6,160,000.00	9,239,944.15
19	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,206,693.16	81,112,800.00
20	Тэтгэврийн даатгал	47,423,000.44	65,740,400.00
21	Тэтгэмжийн даатгал	9,620,719.05	3,843,100.00
22	ҮОМШӨ-ний даатгал	3,243,695.30	3,074,500.00
23	Ажилгүйдлийн даатгал	809,791.66	768,600.00
24	Эрүүл мэндийн даатгал	8,109,486.71	7,686,200.00
25	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,342,953.68	20,835,939.00
26	Гэрэл, цахилгаан	1,636,846.78	1,412,005.00
27	Түлш, халаалт	17,591,438.00	17,591,513.00
28	Цэвэр, бохир ус	1,114,668.90	1,832,421.00
29	Байрны түрээс	0.00	0.00
30	Хангамж, бараа материалын зардал	19,118,786.17	34,150,593.50
31	Бичиг хэрэг	11,116,933.10	8,091,613.50
32	Тээвэр, шатахуун	2,528,497.00	2,212,600.00
33	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,577,447.17	1,708,820.81
34	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,895,908.90	22,137,559.19
35	Эд хогшил, урсгал засварын зардал	1,162,300.00	601,800.00
36	Багаж, техник, хэрэгсэл	309,100.00	34,100.00
37	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	723,200.00	220,000.00
38	Урсгал засвар	130,000.00	347,700.00
39	Томилолт, зочны зардал	1,761,600.00	242,600.00
40	Дотоод албан томилолт	1,761,600.00	242,600.00
41	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,393,768.50	12,219,076.50
42	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	755,600.00	420,200.00
43	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	182,000.00
44	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,314,168.50	11,616,876.50
45	Бараа үйлчилгээний бусад зардал	174,098,526.32	110,257,761.43
46	Бараа үйлчилгээний бусад зардал	165,944,900.00	92,784,300.00
47	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	712,600.00	630,000.00
48	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,441,026.32	16,843,461.43
49	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,163,152.51	653,461.00
50	Бусад урсгал шилжүүлэг	418,200.00	336,000.00
51	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	418,200.00	336,000.00
52	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,744,952.51	317,461.00
53	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,744,952.51	317,461.00
54	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	24,673,188.18	180,091,618.85

55	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	657,589.90
56	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	575,089.90
57	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	0.00	82,500.00
58	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	24,673,188.18	179,434,028.95

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	45,048,296.86	45,048,296.86
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	45,048,296.86	45,048,296.86
5	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	24,673,188.18	24,673,188.18
6	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	69,721,485.04	69,721,485.04
6	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	69,721,485.04	69,721,485.04
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	69,721,485.04	69,721,485.04
10	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	179,434,028.95	179,434,028.95
11	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0.00	0.00	249,155,513.99	249,155,513.99

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	835,604,410.00	771,541,258.62
2	ТАТВАРЫН ОРЛОГО	138,224,510.00	146,545,158.62
3	Бусад татвар, төлбөр, хураамж	138,224,510.00	146,545,158.62
4	Бусад нийтлэг төлбөр, хураамж	138,224,510.00	146,545,158.62
5	Улсын тэмдэгтийн хураамж	138,224,510.00	146,545,158.62
6	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	697,379,900.00	624,996,100.00
7	Улсын төвлөрсөн төсвөөс	531,435,000.00	532,211,800.00
8	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	531,435,000.00	532,211,800.00
9	Нэмэлт санхүүжилтийн орлого	165,944,900.00	92,784,300.00
10	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	165,944,900.00	92,784,300.00
11	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	835,294,410.00	771,531,258.62
12	УРСГАЛ ЗАРДАЛ	835,294,410.00	771,531,258.62
13	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	690,906,747.49	624,342,639.00

14	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	416,376,887.88	415,025,700.00
15	Үндсэн цалин	338,072,045.08	354,759,058.77
16	Нэмэгдэл	72,144,842.80	51,026,697.08
17	Унаа хоолны хөнгөлөлт	6,160,000.00	9,239,944.15
18	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,206,693.16	81,112,800.00
19	Тэтгэврийн даатгал	47,423,000.44	65,740,400.00
20	Тэтгэмжийн даатгал	9,620,719.05	3,843,100.00
21	ҮОМШӨ-ний даатгал	3,243,695.30	3,074,500.00
22	Ажилгүйдлийн даатгал	809,791.66	768,600.00
23	Эрүүл мэндийн даатгал	8,109,486.71	7,686,200.00
24	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,342,953.68	20,835,939.00
25	Гэрэл, цахилгаан	1,636,846.78	1,412,005.00
26	Түлш, халаалт	17,591,438.00	17,591,513.00
27	Цэвэр, бохир ус	1,114,668.90	1,832,421.00
28	Хангамж, бараа материалын зардал	14,049,212.77	11,724,700.00
29	Бичиг хэрэг	7,046,866.60	5,887,079.19
30	Тээвэр, шатахуун	1,816,000.00	2,212,600.00
31	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,577,446.17	1,708,820.81
32	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,700.00	0.00
33	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,607,200.00	1,916,200.00
34	Эд хогшил, урсгал засварын зардал	1,432,300.00	1,384,400.00
35	Багаж, техник, хэрэгсэл	579,100.00	816,700.00
36	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	723,200.00	220,000.00
37	Урсгал засвар	130,000.00	347,700.00
38	Томилолт, зочны зардал	1,761,600.00	242,600.00
39	Дотоод албан томилолт	1,761,600.00	242,600.00
40	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,079,600.00	602,200.00
41	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	755,600.00	420,200.00
42	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	182,000.00
43	Бараа үйлчилгээний бусад зардал	166,657,500.00	93,414,300.00
44	Бараа үйлчилгээний бусад зардал	165,944,900.00	92,784,300.00
45	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	712,600.00	630,000.00
46	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	144,387,662.51	147,188,619.62
47	Бусад урсгал шилжүүлэг	418,200.00	336,000.00
48	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	418,200.00	336,000.00
49	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	143,969,462.51	146,852,619.62
50	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,744,952.51	317,461.00
51	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	138,224,510.00	146,535,158.62

52	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	310,000.00	10,000.00
53	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	310,000.00	0.00
54	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	310,000.00	0.00
55	Дотоод эх үүсвэрээр	310,000.00	0.00
56	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	310,000.00	0.00
57	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-310,000.00	0.00
58	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	10,000.00
59	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
60	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	10,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	532,211,800.00	531,894,339.00	317,461.00	99.9
2	УРСГАЛ ЗАРДАЛ	532,211,800.00	531,894,339.00	317,461.00	99.9
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	531,875,800.00	531,558,339.00	317,461.00	99.9
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	415,025,700.00	415,025,700.00	0.00	100.0
5	Үндсэн цалин	354,759,000.00	354,759,058.77	-58.77	100.0
6	Нэмэгдэл	51,026,700.00	51,026,697.08	2.92	100.0
7	Унаа хоолны хөнгөлөлт	9,240,000.00	9,239,944.15	55.85	100.0
8	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,112,800.00	81,112,800.00	0.00	100.0
9	Тэтгэврийн даатгал	65,740,400.00	65,740,400.00	0.00	100.0
10	Тэтгэмжийн даатгал	3,843,100.00	3,843,100.00	0.00	100.0
11	ҮОМШӨ-ний даатгал	3,074,500.00	3,074,500.00	0.00	100.0
12	Ажилгүйдлийн даатгал	768,600.00	768,600.00	0.00	100.0
13	Эрүүл мэндийн даатгал	7,686,200.00	7,686,200.00	0.00	100.0
14	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,118,600.00	20,835,939.00	282,661.00	98.7
15	Гэрэл, цахилгаан	1,694,500.00	1,412,005.00	282,495.00	83.3
16	Түлш, халаалт	17,591,600.00	17,591,513.00	87.00	100.0
17	Цэвэр, бохир ус	1,832,500.00	1,832,421.00	79.00	100.0
18	Хангамж, бараа материалын зардал	11,724,700.00	11,724,700.00	0.00	100.0
19	Бичиг хэрэг	5,887,000.00	5,887,079.19	-79.19	100.0
20	Тээвэр, шатахуун	2,212,600.00	2,212,600.00	0.00	100.0
21	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,708,900.00	1,708,820.81	79.19	100.0
22	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,916,200.00	1,916,200.00	0.00	100.0
23	Эд хогшил, урсгал засварын зардал	1,384,400.00	1,384,400.00	0.00	100.0
24	Багаж, техник, хэрэгсэл	816,700.00	816,700.00	0.00	100.0
25	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	220,000.00	220,000.00	0.00	100.0

26	Урсгал засвар	347,700.00	347,700.00	0.00	100.0
27	Томилолт, зочны зардал	242,600.00	242,600.00	0.00	100.0
28	Дотоод албан томилолт	242,600.00	242,600.00	0.00	100.0
29	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	637,000.00	602,200.00	34,800.00	94.5
30	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	455,000.00	420,200.00	34,800.00	92.4
31	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	182,000.00	182,000.00	0.00	100.0
32	Бараа үйлчилгээний бусад зардал	630,000.00	630,000.00	0.00	100.0
33	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	630,000.00	630,000.00	0.00	100.0
34	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	336,000.00	336,000.00	0.00	100.0
35	Бусад урсгал шилжүүлэг	336,000.00	336,000.00	0.00	100.0
36	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	336,000.00	336,000.00	0.00	100.0
37	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	532,211,800.00	531,894,339.00	317,461.00	99.9
38	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	532,211,800.00	531,894,339.00	317,461.00	99.9
39	Улсын төсвөөс санхүүжих	532,211,800.00	531,894,339.00	317,461.00	99.9
40	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	10,000.00	-10,000.00	
41	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	10,000.00	-10,000.00	
42	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	10,000.00	-10,000.00	
43	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.0
44	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.0
45	АЖИЛЛАГСАДЫН ТОО	35	35	0.00	100.0
46	Удирдах ажилтан	1	1	0.00	100.0
47	Гүйцэтгэх ажилтан	34	34	0.00	100.0
48	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	35	35	0.00	100.0
49	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	30	30	0.00	100.0
50	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	0.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	92,784,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	92,784,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	92,784,300.00
2104	Бараа үйлчилгээний бусад зардал	92,784,300.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	92,784,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	92,784,300.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	92,784,300.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Мөнгөншагай гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24 -ны өдрийн 145 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь “Иргэн, аж ахуй нэгжид бүртгэлийн ангилалыг тогтоох, бүртгэлийн үнэн зөв байдлыг хангах, төрийн үйлчилгээг түргэн шуурхай авах нөхцөлийг бүрдүүлэх, түүнчлэн улсын бүртгэлийн үйл ажиллагааны зарчим, төрөл, мэдээллийн нэгдсэн сан, улсын бүртгэлийн байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, бүрэн эрх, улсын бүртгэлийг хөтлөхтэй холбогдсон нийтлэг харилцааг зохицуулах” чиг үүрэг бүхий Хууль зүй дотоод хэргийн яамны харъяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант “Улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэхэд оршино” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд УБЕГ-аас төлөвлөгөөт хяналт шалгалт хийх байсан боловч ковид-19 цар тахлын улмаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 532.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 5.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар буюу 4.0 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 179.4 сая төгрөгөөр буюу 257.4 хувиар өсч материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/			
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Бараа материал	23.4	48.8	25.4	108.5
Үндсэн хөрөнгө	46.3	200.3	154.0	332.6
Нийт хөрөнгө	69.7	249.1	179.4	257.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	69.7	249.1	179.4	257.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	69.7	249.1	179.4	257.4

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл 108.5 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 23.4 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 27.3 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 58.8 сая төгрөг нийт 86.1 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 60.6 сая төгрөгийн зарцуулалт гарч, 48.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 332.6 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 46.3 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 172.9 сая төгрөг хөрөнгө нэмэгдсэн бол тайлант хугацаанд байгуулсан 18.9 сая төгрөгийн элэгдлээр буурч оны эцэст 200.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүн 179.4 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/төгрөгөөр/		
	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	531.4	532.2	0.8
Нэмэлт санхүүжилтийн орлого	165.9	92.7	(73.2)
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	24.2		(24.2)
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	21.3	58.8	37.5
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1.4	171.4	170.0
Үйл ажиллагааны орлого	744.2	855.1	110.9
Цалин, шимтгэлийн зардал	485.6	496.1	10.5
Бусад бараа үйлчилгээний зардал	227.8	178.3	(49.5)
Урсгал шилжүүлэг	6.2	0.7	(5.5)
Үйл ажиллагааны зардал	719.6	675.1	(44.5)
Үйл ажиллагааны бус зардал	-	0.6	0.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	24.6	179.4	154.8

Улсын бүртгэлийн хэлтсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 170.0 сая төгрөгөөр өссөн нь УБЕГ-аас сумдын тоног төхөөрөмжийг шинэчлэсэнтэй мөн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал 37.2 сая төгрөгөөр өссөн нь ковид-19 цар тахлын үед халдвар хамгааллын дэглэмийг сахих үүднээс олгосон материалтай тус тус холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 627.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 152.0 сая төгрөгөөр бууруулж, зардлыг 475.1 сая төгрөгөөр хянаж баталсан байна. Харин тайлант онд батлагдсан төсвийн дүнг 10.7 хувиар буюу 532.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгожээ. Төсөв нэмэгдүүлсэн шалтгаан нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн төсөв хүрэхгүйгээс 59.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагч 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 532.2 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, 531.9 сая төгрөгийг зарцуулж, 0.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, тайлант онд батлагдсан төсвийг 2.1%-иар хэмнэж төсвийн хэмнэлтийг бий болгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулах зардалд 92.8 сая төгрөгийн санхүүжилт ирснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлангийн жилд тус байгууллагын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байсан Г.Галсандорж нь Төрийн албаны сонгон шалгаруулалтанд тэнцэн УБЕГ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Б/687 тоот тушаалаар тухайн байгууллагын даргаар томилогдон ажиллаж байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 8 үндсэн зорилтын хүрээнд 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 81.7 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 532.2 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 99.9 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Албан томилолт, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
- Мөн УБХ-ийн төсвийг анх 475.1 сая төгрөгөөр баталсан бол тодотголоор 532.2 сая төгрөгөөр буюу 57.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Учир нь УБХ-ийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлууд сард дунджаар 5.9 сая төгрөгөөр дутагдаж байсантай холбогдуулан тус зардлуудыг 59.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн бол бусад зардлыг 2.8 сая төгрөгөөр бууруулсан байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэл байхгүй тул судалгааг гаргаж ирүүлээгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Улсын бүртгэлийн хэлтэс нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 149 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 7.9 % буюу 1.2 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43-р тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлагыг хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилты холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасан зарчмыг хэрэгжүүлж, холбогдох хууль, журам, төсвийн удирдамжийн дагуу бодит нөхцөлд үндэслэсэн үнэн зөв төсвийн төслийг боловсруулах зөвлөмж хүргүүлснийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар тухайн байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 65 нэр төрлийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээг авах зөвлөмж өглөө.

4.1 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 65 нэр төрлийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тухайн хөрөнгийг Өмч хамгаалах байнгын зөвлөлөөрөө хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж одоо ашиглаж байгаа болон цаашид ашиглагдах хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэн Сангийн Сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “НББ-ийн дансны заавар”-ын 4.39-т заасны дагуу бүртгэл тайланд тусгах, харин ашиглалтын хугацаа дууссан, ашиглагдахгүй болсон хөрөнгийг ТБОНӨТХуулийн 31 дэх заалтын дагуу арга хэмжээ авч ажиллах

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
					Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал												
1	УБХэлтэс	Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 65 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй.	1								1	
Дүн			1								1	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал												
1	УБХэлтэс		1	1.2					1	1.2		
Дүн			1	1.2					1	1.2		
Нийт дүн			2	1.2					1	1.2	1	